



Зохицуулалтын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааны үр дүн

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2025 оны 3-р сард Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс зохицуулалтын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаа авч, дүнг нэгтгэн гаргалаа.

Судалгааны хүрээнд зохицуулалтын үйл ажиллагааны өнөөгийн байдал, шударга өрсөлдөх нөхцөл, Зохицуулах хорооны үйл ажиллагаа, засаглал, чадамж, ил тод нээлттэй байдлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зүгээс хэрхэн үнэлж, дүгнэж байгаа болон тэдэнд тулгарч байгаа бэрхшээл, санал сэтгэгдлийг авч үзсэн болно.

Судалгаанд үнэтэй цаг заваа зарцуулж, идэвх зүтгэл гарган оролцож, санал сэтгэгдлээ хуваалцсан тусгай зөвшөөрөл эзэмшигчдэдээ талархал илэрхийлье!

Судалгааны эх олонлог: Харилцаа холбооны 896 тусгай зөвшөөрөл болон бүртгэлтэй үйлчилгээ эрхлэгчид

Судалгааны түүвэр: Нийт 369 (үүнээс орон нутгийн 74) аж ахуйн нэгж, байгууллагыг тусгай зөвшөөрлийн төрлөөр түүвэрлэн хамруулсан.

Судалгааны арга зүй: Тоон судалгаа. Тоон судалгааг тусгай зөвшөөрөл тус бүрээр асуулгын хуудсаар Survey Monkey цахим платформ ашиглан гүйцэтгэсэн. Судалгаанд харилцаа холбооны салбарт болон тухайн байгууллагадаа урт хугацаанд ажилласан туршлагатай, дунд болон дундаас дээш түвшний мэргэжилтнүүдийг хамруулсан.

Судалгааг гүйцэтгэгч: ХХЗХ-ны ЗЗҮТЗГ-ын Судалгаа шинжилгээний хэлтэс


Судалгаа авсан хугацаа: 2025.03.14 – 2025.03.30

Судалгааны үр дүнг танилцуулсан: 2025.06-р сар

Судалгааны үр дүн

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор үнэлсэн бөгөөд судалгааны үр дүнд **сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ 3.7** оноогоор үнэлэгдсэн нь 2022 оны дүнтэй харьцуулахад 0.2 оноогоор буурсан дүн байв. Мөн онтой харьцуулахад сэтгэл ханамжийн түвшин нь ач холбогдлын түвшнээс 0.2 оноогоор бага байна.


Сэтгэл ханамжийн түвшин, өмнөх онуудтай харьцуулахад





Сэтгэл ханамжийг тодорхойлохдоо **Тусгай зөвшөөрөл, Зохицуулах хорооны үйл ажиллагаа, Зохицуулах хорооны хэрэгжүүлж буй зохицуулалтын үйл ажиллагаа, Засаглал** гэсэн 4 дэд үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг тооцсон.


Сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ, дэд үзүүлэлт тус бүрээр



Дэд үзүүлэлт тус бүрээр сэтгэл ханамжийн үнэлгээг авч үзвэл Зохицуулах хорооны хэрэгжүүлж буй зохицуулалтын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ дунджаас доогуур 3.6, мөн ач холбогдлын түвшин 0.4 буюу хамгийн их зөрүүтэй байна.

Сэтгэл ханамжийн үнэлгээг тусгай зөвшөөрлийн төрлөөр нь авч үзвэл Харилцаа холбооны сүлжээ, Телевиз, Радио, Сүлжээ дэд бүтцийн суурилуулалт тусгай зөвшөөрөл болон тусгай дугаарын бүртгэлтэй үйлчилгээ эрхлэгчид дунджаас доогуур сэтгэл ханамжтай байна.

Сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ, тусгай зөвшөөрлийн төрлөөр





Тусгай зөвшөөрөлтэй холбоотой дэд үзүүлэлтийн хувьд Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрлийн төрлийн нийцтэй байдал, тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэргэжлийн заавар, зөвлөмж өгөх байдалд тусгай зөвшөөрөл эзэмшигчид дунджаас бага зэрэг доогуур сэтгэл ханамжтай байв.

Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг ерөнхийд нь нэгтгэн дүгнэхэд:

1. Сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ 3.9-өөс 3.7 болж буурсан нь Зохицуулах хорооны үйл ажиллагаанд өгөх ач холбогдол, итгэл, үйлчилгээний чанар буурсан байж болзошгүй тул онцгойлон анхаарах;

2. Хүлээлт болон бодит байдлын зөрүүг илэрхийлсэн GAP үнэлгээ 0.4-өөс 0.2 болж багассан нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээлтэд илүү ойртож ирсэн гэж эергээр дүгнэж болно.

3. ХХЗХ-ны үйл ажиллагаа хэсгийн сэтгэл ханамжийн үнэлгээ дунджаас доогуур гарахад байгууллагын гадаад орчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал болон мэдээллийн хүртээмжтэй, ил тод байдал дутмаг байгаа нь нөлөөлсөн.

4. Харин зохицуулалтын үйл ажиллагаа дэд бүлгийн үнэлгээ дунджаас доогуур гарахад зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлсэн байдал (телевиз, харилцаа холбооны сүлжээний үйлчилгээ), салбар хоорондын зохицуулалт, зах зээлд давамгайл байдалтай аж ахуйн нэгжийн үйлчилгээний тарифын зохицуулалтын оновчтой байдал үзүүлэлтийн үнэлгээ бага гарсан нь нөлөөлсөн.

5. ХХЗХ-ны засаглалын байдалд тусгай зөвшөөрөл эзэмшигчид харьцангуй сэтгэл ханамжтай байгаа ч ХХЗХ-ны хараат бус байдал төдийлөн хангалтгүй байгааг илэрхийлсэн.

6. ХХЗХ-ны үйл ажиллагааны чухал хэсэг болох тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ дунджаас дээгүүр гарч, тусгай зөвшөөрөл эзэмшигчид цахимаар хүсэлт хүлээн авч шийдвэрлэх байдалд сайн үнэлгээ өгчээ. Харин мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх байдалд сэтгэл ханамж харьцангуй доогуур байна.

Цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигчийн туршлага, мэдлэгийг өөрчилснөөр сэтгэл ханамжийн түвшин сайжрах боломжтой бөгөөд Зохицуулалтын чиг хандлагын талаар олон улсын судалгаа мэдээллийг түгээх, салбарын статистик болон зах зээлийн судалгаа мэдээллийг илүү хүртээмжтэй болгох, Зохицуулах хорооны бүтэц, бүрэлдэхүүнийг таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах шаардлагатай байгааг судалгааны үр дүн харуулсан.

Тус хороо нь үйл ажиллагаагаа сайжруулах, стратеги зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохдоо энэхүү сэтгэл ханамжийн судалгааны дүнд ач холбогдол өгч, сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлтийг дээшлүүлэхээс гадна бага үнэлгээ авсан үзүүлэлт тус бүрийн шалтгааныг арилгах, сайжруулахад анхаарч ажиллаж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо

ЗЗҮТЗГ, Судалгаа шинжилгээний хэлтэс

2025 он